



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/91/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 145

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд зардлын гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн, Засгийн газар болон яамны шагнал авсан ажилтнуудад мөнгөн шагнал олгосон, Сумын онцгой комисст хүнс олгосон, Санхүүгийн тайлангийн өглөг, татварын хэлтсээс авсан тодорхойлолтоос зөрүүтэй тайлагнасан, Батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулсан зэрэг нийт 196,0 сая төгрөгийн зөрчлүүд нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, БШУСайдын 2020 оны А/23 тоот тушаалаар батлагдсан журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журам зэрэг эрх зүйн акттай нийцэхгүй байгаа бөгөөд зохистой байх, үнэн зөв ба толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Ү зүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	104,791,943.36	109,732,501.16
33	АВЛАГА	-	133,636.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	133,636.38
35	БАРАА МАТЕРИАЛ	104,791,943.36	109,598,864.78
35100	Түүхий эд материал	37,547,062.00	37,547,062.00
35110	Тусгай зориулалттай материал	37,547,062.00	37,547,062.00
35400	Хангамжийн материал	67,244,881.36	72,051,802.78
35410	Бичиг хэргийн материал	487,100.00	472,050.00
35420	Аж ахуйн материал	62,486,131.36	65,383,462.86
35440	Түлш, шатах тослох материал	100,000.00	-
35450	Барилгын засварын материал	122,000.00	-
35460	Хүнсний материал	160,150.00	554,600.00
35470	Бусад хангамжийн материал	3,889,500.00	5,641,689.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,683,127,835.20	2,512,768,242.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,683,127,835.20	2,512,768,242.34
39200	Биет хөрөнгө	2,617,914,835.20	2,449,615,242.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,697,020,760.26	2,640,999,378.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(176,096,884.82)	(275,455,560.50)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,401,438.01	111,026,627.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,465,767.00)	(81,526,477.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,355,414.50	72,555,945.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	(56,360,726.75)	(44,045,271.16)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,980,423.00	13,980,423.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,080,178.00	12,080,178.00
39300	Биет бус хөрөнгө	65,213,000.00	63,153,000.00
39301	Програм хангамж	1,250,000.00	790,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,025,000.00)	(625,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,988,000.00	74,988,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,000,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,787,919,778.56	2,622,500,743.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,238,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,238,000.00	-
41300	Өглөг	15,238,000.00	-
41360	Бусад өглөг	15,238,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	15,238,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,772,681,778.56	2,622,500,743.50
51	Засгийн газрын хувь оролцоо	2,772,681,778.56	2,622,500,743.50
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	642,355,562.85	642,355,562.85
51200	Хуримтлагдсан үр дүн	1,591,230,716.85	1,442,291,063.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,688,091,973.16	1,592,472,098.49
51220	Тайлант үеийн үр дүн	(96,861,256.31)	(150,181,035.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	539,095,498.86	537,854,117.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,787,919,778.56	2,622,500,743.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,028,660,068.00	1,000,725,747.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,668,048.00	17,672,616.42
120	Нийтлэг татварын бус орлого	48,668,048.00	17,672,616.42
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	48,668,048.00	13,846,352.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материал		3,826,264.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	979,992,020.00	983,053,131.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	796,648,900.00	786,611,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	796,648,900.00	786,611,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,531,420.00	5,970,831.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,436,700.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,837,020.00	5,970,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	257,700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,811,700.00	190,471,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,811,700.00	190,471,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,125,521,324.31	1,106,889,982.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,125,521,324.31	1,106,889,982.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,045,696,818.60	1,087,690,174.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,479,674.76	647,053,012.63
210101	Үндсэн цалин	582,692,997.42	589,363,013.14
210104	Урамшуулал	50,786,677.34	57,689,999.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,965,733.53	84,030,344.71
210201	Тэтгэврийн даатгал	60,820,841.45	61,071,605.29
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,559,192.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,112,352.71	4,951,799.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,275,777.13	1,188,392.03
210205	Эрүүл мэндийн даатгал	12,756,762.24	11,259,356.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,862,661.00	172,891,290.00
210301	Гэрэл, цахилгаан	3,695,651.00	3,610,131.00
210302	Түлш, халаалт	158,467,010.00	166,213,159.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	3,068,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,471,555.00	9,726,292.00
210401	Бичиг хэрэг	1,049,700.00	1,191,750.00
210402	Тээвэр, шатахуун	6,910,605.00	2,876,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,900.00	738,499.00
210404	Ном, хэвлэл	89,200.00	38,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,021,150.00	4,821,043.00
2105	Нормативт зардал	20,180,150.00	23,480,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	980,200.00	1,443,100.00
210502	Хоол, хүнс	18,756,950.00	22,007,090.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	443,000.00	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	1,827,900.00
210604	Урсгал засвар	200,000.00	1,827,900.00
2107	Томилолт, зочны зардал	695,600.00	524,000.00
210702	Дотоод албан томилолт	695,600.00	524,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,174,750.00	240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,598,750.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,666,694.31	147,917,145.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	865,200.00	3,614,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	130,801,494.31	144,303,145.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,824,505.71	19,199,808.28

Говь-Алтай аймгийн Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	43,605,691.00	15,766,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,253,800.00	10,878,190.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,767,020.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,584,871.00	4,888,790.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	204,349.00	613,910.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	204,349.00	613,910.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,014,465.71	2,818,918.28
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,014,465.71	2,818,918.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(96,861,256.31)	(106,164,235.30)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	44,016,799.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	44,016,799.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(44,016,799.76)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(96,861,256.31)	(150,181,035.06)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,355,562.85	539,095,498.86	1,688,091,973.16	2,869,543,034.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,355,562.85	539,095,498.86	1,688,091,973.16	2,869,543,034.87
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(96,861,256.31)	(96,861,256.31)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,355,562.85	539,095,498.86	1,591,230,716.85	2,772,681,778.56
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	642,355,562.85	539,095,498.86	1,591,230,716.85	2,772,681,778.56
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,241,381.64	1,241,381.64
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,355,562.85	539,095,498.86	1,592,472,098.49	2,773,923,160.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,241,381.64)	-	(1,241,381.64)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(150,181,035.06)	(150,181,035.06)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	642,355,562.85	537,854,117.22	1,442,291,063.43	2,622,500,743.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	981,805,620.00	983,053,131.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	981,805,620.00	983,053,131.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	796,648,900.00	786,611,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	796,648,900.00	786,611,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,345,020.00	5,970,831.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,436,700.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,650,620.00	5,970,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	257,700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,811,700.00	190,471,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,811,700.00	190,471,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	981,805,620.00	978,939,131.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	981,805,620.00	978,939,131.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,981,114.29	956,533,352.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,479,674.76	647,053,012.63
210101	Үндсэн цалин	582,692,997.42	589,363,013.14
210104	Урамшуулал	50,786,677.34	57,689,999.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,965,733.53	84,163,981.09
210201	Тэтгэврийн даатгал	60,820,841.45	61,205,241.67
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,559,192.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,112,352.71	4,951,799.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,275,777.13	1,188,392.03
210205	Эрүүл мэндийн даатгал	12,756,762.24	11,259,356.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,607,351.00	187,861,290.00
210301	Гэрэл, цахилгаан	3,695,651.00	3,610,131.00
210302	Түлш, халаалт	146,211,700.00	181,351,159.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	2,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,308,505.00	8,554,330.00
210401	Бичиг хэрэг	849,300.00	1,683,031.00
210402	Тээвэр, шатахуун	6,910,605.00	3,044,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,900.00	738,499.00
210404	Ном, хэвлэл	338,700.00	322,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,809,000.00	2,705,800.00
2105	Нормативт зардал	17,677,050.00	21,785,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	963,400.00	1,976,600.00
210502	Хоол, хүнс	16,303,650.00	19,195,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	410,000.00	613,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,395,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,400,000.00
210604	Урсгал засвар	-	1,995,900.00
2107	Томилолт, зочны зардал	695,600.00	524,000.00
210702	Дотоод албан томилолт	695,600.00	524,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,748,000.00	434,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,172,000.00	434,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,499,200.00	2,761,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,499,200.00	2,761,669.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,824,505.71	22,405,778.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,605,691.00	18,972,950.00

Говь-Алтай аймгийн Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,253,800.00	14,084,160.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,767,020.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,584,871.00	4,888,790.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	204,349.00	613,910.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	204,349.00	613,910.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,014,465.71	2,818,918.28
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,014,465.71	2,818,918.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	4,114,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,114,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,114,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,114,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		4,114,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,114,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	977,082,300.00	973,649,471.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	977,082,300.00	973,649,471.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	957,482,600.00	954,676,521.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,453,100.00	647,053,012.63
210101	Үндсэн цалин	589,763,100.00	589,363,013.14
210104	Урамшуулал	57,690,000.00	57,689,999.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,227,400.00	84,163,981.09
210201	Тэтгэврийн даатгал	61,633,000.00	61,205,241.67
210202	Тэтгэмжийн даатгал	6,111,600.00	5,559,192.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,955,800.00	4,951,799.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,230,400.00	1,188,392.03
210205	Эрүүл мэндийн даатгал	11,296,600.00	11,259,356.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,471,100.00	187,861,290.00
210301	Гэрэл, цахилгаан	4,113,100.00	3,610,131.00
210302	Түлш, халаалт	181,458,000.00	181,351,159.00
210303	Цэвэр, бохир ус	2,900,000.00	2,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,335,700.00	7,059,499.00
210401	Бичиг хэрэг	888,200.00	888,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,345,000.00	2,344,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	738,499.00
210404	Ном, хэвлэл	322,500.00	322,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,705,800.00
2105	Нормативт зардал	22,055,400.00	21,785,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	1,976,600.00
210502	Хоол, хүнс	19,355,400.00	19,195,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	613,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200,000.00	5,195,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,995,900.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	402,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	402,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	515,000.00	434,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	515,000.00	434,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	724,900.00	721,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	724,900.00	721,669.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,599,700.00	18,972,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,599,700.00	18,972,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,599,700.00	14,084,160.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	4,888,790.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	977,082,300.00	973,649,471.72
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	786,611,200.00	783,792,281.72
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	786,611,200.00	783,792,281.72
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	190,471,100.00	189,857,190.00
320001	Орон нутгийн төсвөөс	190,471,100.00	189,857,190.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,970,831.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,970,831.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,970,831.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,494,831.00
210401	Бичиг хэрэг	794,831.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	122,000.00
210702	Дотоод албан томилолт	122,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,954,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,970,831.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,970,831.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,970,831.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 8 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,416.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 28.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 22.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 1,094.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6 хувиар буюу 164.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109.6 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 48.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 43.6 сая төгрөгийн материалыг зарцуулж, 1.0 сая төгрөгийн хүнсийг сумын өгч, оны эцэст 108.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,916.4 сая төгрөг болж 81.6 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн өмчийн албаны шийдвэрээр 89.6 сая төгрөгийн барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталсантай холбоотой

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,623.3 сая төгрөг болж 149.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 8 хувиар буюу 103.4 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө оруулалт холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 642.3 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,089.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 112.0 сая төгрөгөөр бууруулж, 977.0 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 977.0 сая төгрөгийн төсөв баталснаас 786.5 сая төгрөгийг улсын төсвөөс 190.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 786.5 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 190.5 сая төгрөг, нийт 977.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 973.6 сая төгрөгийг зарцуулж 2.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0.6 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 973.6 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 0.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.0 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.6 сая төгрөгөөр, нормативд зардлыг 0.3 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 1.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 5.9 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 1.4 сая төгрөгийг багаж техник хэрэгсэлд, 2.9 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд, 0.1 сая төгрөгийг дотоод албан томилолтод, 1.5 сая төгрөгийг хангамж бараа материал худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 420.5 сая төгрөгийн 55 мэдээллийг ил тод байршуулахаас 241.8 сая төгрөгийн 20 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Худалдан авалтын 30.8 сая төгрөгийн и баримтыг цахимд дутуу оруулсан байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 43.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн ба шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг авч үзэх

- Бараа материалын тайлангийн тулгалт,
- Хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 228.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 226.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй ирсэн 1.2 сая төгрөгийн материалыг бараа материалыг дансанд бүртгэж, залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Засгийн газар болон яамны шагнал авсан ажилтнуудад 0.6 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, БШУСайдын 2020 оны А/23 тоот тушаалаар батлагдсан журамтай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Худалдан авалтын 30.7 сая төгрөгийн и баримтыг цахимд дутуу оруулсан нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 420.5 сая төгрөгийн 55 мэдээллийг ил тод байршуулахаас 241.8 сая төгрөгийн 20 мэдээллийг ил тод байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" мэдээлнэ гэж заасан заалтыг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 190.2 сая төгрөгийн зардлын гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих,

- 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1 “Үнэн зөв ба толилуулга, нийцсэн байдал”-ыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
 - Батлагдсан орон тооноос эрүүл мэндийн багшийн 1 орон тоо илүү ажиллуулж 3,9 төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” Боловсрол соёл урлагийн газрын даргын 2021 оны 10 сарын 14-ны 258 дугаар тушаалтай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
 - Сумын онцгой комисст 1.0 сая төгрөгийн хүнс өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалтай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
 - Санхүүгийн тайлангийн өглөг, татварын хэлтсээс авсан тодорхойлолтоос 0.3 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дарив сумын Ерөнхий боловсролын сургууль	8	228.1	1	1.2	1	0.6	6	226.3		
	Дүн	8	228.1	1	1.2	1	0.6	6	226.3		